



**ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН “ОЮУНЫ УУРХАЙ”
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 1/08

Бор-Өндөр сум

┌ Үсэглэлийн баярыг зохион байгуулах тухай ┐

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.3, 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалт, Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 1/1232 дугаар албан бичиг, Хэнтий аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 207 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн нэгдүгээр ангийн үсэглэлийн баярын үйл ажиллагааг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр үг үсэглэл, мэдсэн, сурсан авьяасаа тайлагнах сурагчдын тайлант өдөрлөг хэлбэрээр зохион байгуулсугай.

2. Үсэглэлийн баяраар сурагчийн зөвлөл, эцэг эхийн зөвлөлийн санаачилга нэрээр бэлэн мөнгө татах, багшид бэлэг өгөх, архи дан согтуурах, хооллож ундлах, амралт зугаалга зэрэг эцэг эхэд санхүүгийн дарамт учруулах үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглосугай.

3. Энэхүү тушаалыг дагаж биелүүлээгүй, зөрчсөн багш, ажилтанд хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээ тооцуулахаар холбогдох албан тушаалтанд уламжлахыг нийгмийн ажилтан (Э.Нарантуяа)-д даалгасугай.

4. Дээрх үйл ажиллагааг чанартай зохион байгуулж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллахыг сургалтын менежер (М.Нармандах), дотоод хяналтын ахлагч (Л.Ганганмөрөн), нийгмийн ажилтан (Э.Нарантуяа), анги удирдсан багш нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.АМАРЖАРГАЛ